



ОНЦЛОХ МЭДЭЭ :

- Монгол Улсын гадаад секторын статистик мэдээллийг нэгтгэсэн тоймын 2 дахь дугаарыг танилцуулж байна.
- Төлбөрийн тэнцлийн ашиг энэ оны 1 дүгээр улиралд өмнөх оноос 9.4 дахин нэмэгдэж байсан бол 2 дугаар улиралд 1.6 дахин буурчээ.
- Урсгал дансны алдагдал 667.6 сая ам.долларт хүрлээ.
- Монгол Улсын нийт гадаад зээлийн үлдэгдэл 11.4 тэрбум ам.долларт хүрлээ.

АГУУЛГА

Төлбөрийн тэнцэл	2
Гадаад хөрөнгө	4
Нийт гадаад зээл	5
Хавсралт	6

Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс

Монголбанк
Бага тойруу 3,
Улаанбаатар 15160
Утас: 976-11-323243,
314969, 318304, 327088

Факс: +976-11-327088
Email:
bor@mongolbank.mn

Төлбөрийн тэнцэл (BOP)

2012 оны 2-р улирлын гүйцэтгэлээр урсгал данс 667.6 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 390.7 сая долларын ашигтай, алдаа ба орхигдуулга 389.2 сая ам.доллар гарснаар, төлбөрийн нийт тэнцэл +112.3 сая ам.доллар болж, гадаад валютын албан нөөц уг дүнгээр нэмэгдлээ.

Өмнөх онтой харьцуулахад урсгал дансны алдагдал 1.2 дахин, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 0.4 дахин өссөн нь уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал болон тэдгээрээр санхүүжигдсэн импортын өсөлттэй шууд хамааралтай байна.

Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 5,820.9 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 15,903.6 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц улирлын эцэст -10,082.7 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулж байгаа бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 2.3 дахин буюу 5.8 тэрбум ам.доллараар нэмэгдсэн нь гаднаас орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээлийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2012 оны 2-р улирлын гүйцэтгэлээр 11.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өсчээ.


Энэ нь хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31%-иар өсч 8.7 тэрбум ам.долларт, Засгийн газрын баталгаатайгаар авсан гадаад өр 23%-иар өсч 2.8 тэрбум ам.доллар хүрч тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гадаад секторын статистик гэж юу вэ?


Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг.

Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц



Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



Дүрслэл 4. Статистик хамаарал



I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

УРСГАЛ ДАНС

Тайлант улиралд урсгал тэнцэл 667.6 сая ам.долларын алдагдалтай гарч, 2011 оны мөн үеэс 16%-иар өсчээ.

Урсгал дансны алдагдал ийнхүү өсөхөд барааны дансны алдагдал 249.1 ам долларт хүрч 16%-иар, үйлчилгээний дансны алдагдал 338.1 ам долларт хүрч 26%-иар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.7%-иар өсч 3,006.1 сая ам.долларт хүрлээ.

Монгол улсын экспортын зарим бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ болон биет хэмжээ буурсан, мөн уул уурхайн төслүүдийн хэрэгжилттэй уялдан хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт, дэлхийн зах зээл дэх нефтийн үнийн өсөлт, түүний нийлүүлэлтийн хэлбэлзлээс шалтгаалж импорт нь экспортоос 1 нэгж хувиар илүү хурдацтай өссөнөөр, барааны гадаад худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 16%-иар өссөн байна.

Үйлчилгээний худалдаа

Үйлчилгээний худалдааны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19%-иар өсч 174.9 сая ам.долларт хүрсэн боловч зарлага нь түүнээс илүү хурдацтай буюу 23%-иар өсч 513.0 сая ам.доллар болсон нь үйлчилгээний худалдааны алдагдал 26%-иар нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Үйлчилгээний худалдааны алдагдал ийнхүү өсөхөд импортын барааны тээвэрлэлтийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 26%-иар өсч 319.6 сая ам.долларт, бусад үйлчилгээний зардал 27%-иар өсч 104.0 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлжээ.

Орлого

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдүүд нь харьяат бус хувьцаа эзэмшигчдэдээ 85.9 сая ам.долларын ногдол ашгийг хуваарилж, улмаар гадны хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн эх үүсвэрт 15.7 сая ам.долларын хүү төлсөн бол Монгол Улсын Засгийн газар болон хувийн хэвшлийн салбарынхан гадаадаас авсан зээлийн эх үүсвэрт 19.8 сая ам.доллар, банкууд эдийн засгийн харьяат бус этгээдээс байршуулсан харилцах, хадгаламжийн эх үүсвэрт 8.9 сая ам.долларыг хүүгийн төлбөрт тус тус зарцуулсан байна.

Монгол Улсад ажиллаж буй гадаадын ажиллагсдад олгосон цалин хөлсний хэмжээ 61.1 сая ам.долларт хүрснээр ажиллагсдын цалин хөлсний данс цэвэр дүнгээр 53.6 сая ам.долларын алдагдалтай болж, алдагдлын хэмжээ нь 2011 оны мөн үеэс 2.1 дахин өсчээ. Хөрөнгө оруулалтын орлогын данс 114.0 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2011 оны 2-р улиралтай харьцуулахад 13.9%-иар буурсан үзүүлэлт болов. Эдгээр нь цэвэр орлогын данс тайлант онд 167.6 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлөв.


Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 9%-иар өссөн боловч гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 34%-иар өссөнөөр ажилчдын цэвэр гуйвуулгын дүн 44%-иар буурчээ.


Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая \$)

Үзүүлэлт	2-р улирал		Өөрчлөлт	
	2012	2011	Мөнгөн дүн	Хувь
I. Урсгал тэнцэл	-667.6	-575.8	-91.8	16%
A. Бараа, үйлчилгээний худалдаа	-587.2	-483.9	-103.3	21%
а. Бараа	-249.1	-214.7	-34.4	16%
б. Үйлчилгээ	-338.1	-269.2	-68.9	26%
B. Цэвэр орлого	-167.6	-157.6	-10.0	6%
B. Урсгал шилжүүлэг	87.2	65.7	21.5	33%

Дүрслэл 5. Барааны худалдаа



Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Урсгал шилжүүлэг (мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	78,163	3%	▼ -25%	132,749	5%	▲ 9%
Америк	409,993	14%	▲ 118%	310,732	12%	▲ 11%
Хятад	732,034	24%	▼ -49%	787,437	30%	▼ -48%
Гонг Конг	953,568	32%	▲ 39%	243,854	9%	▲ 3%
Англи	258,828	9%	▲ 14%	90,440	3%	▲ 13%
ОХУ	43,772	1%	▲ 23%	351,447	13%	▲ 10%
Сингапур	86,995	3%	▲ 19%	57,166	2%	▼ -3%
Швейцарь	87,049	3%	▼ -30%	60,263	2%	▼ -28%
Герман	24,419	1%	▼ -34%	56,774	2%	▼ -19%
Япон	36,523	1%	▲ 32%	81,551	3%	▼ -12%
Бусад	292,171	10%	▼ -40%	447,039	17%	▲ 25%
НИЙТ	3,003,515	100%		2,619,452	100%	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга (сая \$)

	2010	2011	2012	Жилийн өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	25.5	20.3	11.3	-9.0	-44%
Гаднаас орж ирсэн	54.4	64.3	70.3	6.0	9%
Гадагш шилжүүлсэн	-28.9	-44.0	-59.0	-15.0	34%

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Тайлант улиралд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 390.7 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 2.5 дахин буурсан үзүүлэлт юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 985.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 27%-иар буюу 364.0 сая ам.доллараар буурчээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтыг ангилал тус бүрээр нь авч үзвэл:

1/ Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар буурч 240.6 сая ам.долларт,

2/ Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилготой зээлийн эх үүсвэрийн санхүүжилт 60 хувиар буурч 608.2 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Нийт хөрөнгө оруулалтын 61% нь Гонг Конгийн хөрөнгийн бирж, банк, санхүүгийн байгууллагаар дамжин санхүүжигдсэн ба энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 6.2 дахин өссөн үзүүлэлтэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2012 оны 2 дугаар улиралд 14.3 сая ам.долларын ашигтай гарахад (I) Монгол Улсын хуулийн этгээдүүд нь эдийн засгийн харьяат бусаас худалдаж авсан үнэт цаасны төлбөрт 3.3 сая ам.долларыг төлсөн (II) Монголын хөрөнгийн бирж болон санхүүгийн зуучлагч компаниудаар дамжуулан гадаадын иргэн, хуулийн этгээдүүдийн худалдаж авсан хөрөнгийн хувьцааны цэвэр дүн 5.7 сая ам.долларын орох урсгалтай байсан (III) Арилжааны банкуудын бонд, өрийн бичгийн өөрчлөлт цэвэр дүнгээр 11.8 сая ам.долларын орох урсгалтай байсан нь тус тус нөлөөлжээ.

Бусад хөрөнгө оруулалт

Тайлант улирлын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд бусад хөрөнгө оруулалтын данс 634.4 сая ам.долларын алдагдалтай гарсан нь банкуудын гадаад актив буюу бэлэн мөнгө ба харилцах дансаар дамжих эх үүсвэрийн орох урсгал 791.0 сая ам.доллараар нэмэгдсэнтэй шууд холбоотой юм.

Харин гадаад пассив тайлант улиралд 143.5 сая ам.долларын эерэг урсгалтай гарсан нь экспортын урьдчилгаа төлбөртэй холбоотой аж ахуйн нэгжийн өглөг 84.2 сая ам.доллар, банкны салбар 42.1 сая ам.долларын гадаад зээлийн эх үүсвэр авсан нь голлон нөлөөлсөн байна.

Алдаа ба орхигдуулга

Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт 389.2 сая ам.доллар гарсан нь эдийн засгийн тэлэлт, хөрөнгийн урсгалын өсөлттэй харьцуулбал бага үзүүлэлт байна.

Түүнчлэн уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь гадагш гарсан хөрөнгийн урсгал буюу гадаад төлбөр тооцоо, гадаад дахь дансны урсгал дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая \$)

Үзүүлэлт	2-р улирал		Өөрчлөлт	
	2012	2011	Мөнгөн дүн	Хувь
II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл	390.7	973.7	-583.0	-60%
<i>A. Хөрөнгийн данс</i>	<i>24.9</i>	<i>27.6</i>	<i>-2.6</i>	<i>-10%</i>
<i>B. Санхүүгийн данс</i>	<i>365.8</i>	<i>946.1</i>	<i>-580.4</i>	<i>-61%</i>
<i>а. Шууд хөрөнгө оруулалт</i>	<i>985.9</i>	<i>1349.9</i>	<i>-364.0</i>	<i>-27%</i>
<i>б. Багцын хөрөнгө оруулалт</i>	<i>14.3</i>	<i>-6.3</i>	<i>20.6</i>	<i>-325%</i>
<i>в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</i>	<i>0.0</i>	<i>0.0</i>	<i>0.0</i>	<i>-</i>
<i>г. Бусад хөрөнгө оруулалт</i>	<i>-634.4</i>	<i>-397.4</i>	<i>-237.0</i>	<i>60%</i>

Хүснэгт 5. Монгол улсад орсон шууд хөрөнгө оруулалт (сая \$)

Хүснэгт 6. Монгол улсад орсон шууд хөрөнгө оруулалт (сая \$)

Салбарын ангиллаар (2011 оны эцсийн байдлаар)


Үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өөрчлөлт* (дахин)
Уул уурхай, ашигт малтмал	4,007.4	85%	3.3 ▲
Харилцаа холбоо	47.1	1%	-1.0 ▼
Барилгын салбар	188.6	4%	1.9 ▲
Банк, санхүүгийн салбар*	141.4	3%	2.2 ▲
Төмөр зам	47.1	1%	2.6 ▲
Үл хөдлөх хөрөнгө	47.1	1%	2.8 ▲
Бусад	235.7	5%	0.8 ▲
Нийт	4714.6	100%	2.8

Орноор (2011 оны эцсийн байдлаар)

Үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өөрчлөлт* (дахин)
БНХАУ	349.3	7%	2.1 ▲
Өмнөд Солонгос	60.8	1%	-4.3 ▼
Канад	419.6	9%	1.6 ▲
Гонг Конг	2,898.9	61%	6.2 ▲
Япон	93.5	2%	4.5 ▲
ОХУ	145.4	3%	1.0 ▲
Англи	138.9	3%	1.4 ▲
АНУ	250.0	5%	0.9 ▲
Европ тив (Англи, ХБНГУ-аас бусад)	90.0	2%	4.4 ▲
Австрали	112.4	2%	4.2 ▲
ХБНГУ	14.5	0%	0.3 ▲
Сингапур	86.9	2%	83.5 ▲
Бусад	54.4	1%	0.3 ▲
Нийт	4714.6	100%	2.8

* Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт

Дүрслэл 7. Улсын гадаад валютын цэвэр албан нөөц



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2012 оны 2-р улирлын эцэст -10,082.7 сая ам.доллар байв.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 10.1 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа улсын өрийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 5,820.9 сая ам.доллар байна. Үүний 50%-ийг гадаад валютын албан нөөц, 31%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 18%-ийг шууд хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 15,903.6 сая ам.долларт хүрчээ. Үүний 70%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 25%-ийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 6%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 39%-ийг буюу 4,351.8 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 61% буюу 6,730.7 сая ам.долларыг толгой компаниаа авсан зээл эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх улирлаас 12%-иар буюу 1,041.8 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 4.0%-иар буюу 228.4 сая ам.доллараар буурч, гадаад пассив 5%-иар буюу 813.4 сая ам.доллараар нэмэгдсэнээр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 15%-иар буюу 1,310.9 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 12%-иар буюу 276.5 сая ам.доллараар тус тус өссөнөөр,
- Гүйлгээ тус бүрээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орлого, зарлагын гүйлгээгээр 702.9 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөр 561.7 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр 214.6 сая ам.доллараар тус тус нэмэгдэж, бусад өөрчлөлтөөр 437.5 сая ам.доллараар буурснаар тус тус тайлбарлагдаж байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэ


Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ 2012 оны 2-р улиралд дунджаар 36.7%-иар буурчээ.

Английн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Петро Матад (Petri Matad) компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 63%-ийн уналттай, Гонг-Конгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Винсвэй Кокинг коал компанийн хувьцаа хамгийн бага уналттай буюу 11%-ийн бууралттай байна.


Хүснэгт 7. Позиц (сая \$)

Үзүүлэлт	6/30/2011	6/30/2012	Өөрчлөлт	
			Дун	Дахин
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-4,297.0	-10,082.7	-5,785.7	2.3
I. Гадаад актив	6,891.3	5,820.9	-1,070.4	0.8
1. Шууд хөрөнгө оруулалт	3,029.2	1,062.5	-1,966.7	0.4
2. Багцын хөрөнгө оруулалт	73.1	24.4	-48.7	0.3
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0.3	0.5	0.2	1.8
4. Бусад хөрөнгө оруулалт	1,247.2	1,825.4	578.2	1.5
5. Нөөц актив	2,541.6	2,908.2	366.5	1.1
II. Гадаад пассив	11,188.3	15,903.6	4,715.3	1.4
1. Шууд хөрөнгө оруулалт	7,489.1	11,082.5	3,593.4	1.5
2. Багцын хөрөнгө оруулалт	302.5	913.9	611.5	3.0
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0.3	0.5	0.2	1.8
4. Бусад хөрөнгө оруулалт	3,396.5	3,906.7	510.2	1.2

Дүрслэл 8. Гадаад актив



Дүрслэл 9. Гадаад пассив



Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ

№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					3/30/2012	6/30/2012	
1	Ivanhoe Mines	IVN	US	USD	15.74	9.68	-38.5%
2	Mongolian Mining Corp	975	HK	HKD	7.38	4.36	-40.9%
3	Centerra Gold	CG	CAD	CAD	15.51	7.12	-54.1%
4	Southgobi Resources	1878	HK	HKD	51.20	29.00	-43.4%
5	Winsway Cocking Coal	1733	HK	HKD	1.56	1.39	-10.9%
6	Mongolia Energy Corp	276	HK	HKD	0.65	0.41	-36.9%
7	Petro Matad	MATD	LN	GBP	26.12	9.62	-63.2%
8	Prophecy Coal Corp	PCY	CAD	CAD	0.42	0.26	-38.6%
9	Haranga resources	HAR	AU	AUD	0.47	0.28	-40.4%
10	Mongolian Investment Group	402	HK	HKD	0.04	0.04	0.0%

III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2012 оны 2-р улирлын байдлаар 11.4 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3.3 тэрбум ам.доллараар буюу 1.4 дахин нэмэгдсэн байна. Үүнийг салбарын хувь хэмжээгээр нь авч үзвэл:

Төрийн байгууллага: Засгийн газар, Монголбанкны гадаад өр 651.0 сая ам.доллараар нэмэгдэж, 2,775.7 сая ам.долларт хүрчээ.

Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд жилийн хугацаанд 2,667.5 сая ам.доллараар нэмэгдэж 8,660.0 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь нийт гадаад өрийн 76%-ийг эзлэж байгаа юм.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2012 оны 2 дугаар улирлын байдлаар 703.2 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 135.9 сая ам.доллараар буюу 1.2 дахин нэмэгджээ.

Уг пассивын 87% нь урт хугацаат бөгөөд үүний 34% нь бонд, өрийн бичиг хэлбэрээр, 33% нь арилжааны зээлийн хэлцэл, 18% нь харилцах, хадгаламжаар, үлдсэн 15% бусад өглөгийн эх үүсвэрүүд эзэлж байна.

Банкууд тайлант улиралд шинээр 38.0 сая ам.долларын урт, 29.9 сая ам.долларын богино хугацаат арилжааны зээлийн хэлцлийг гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай байгуулж, 25.9 сая ам.долларын үндсэн өрийг 4.8 сая ам.долларын хүүгийн төлбөрийн хамтаар гадаад талд барагдуулжээ.

Банкны бус салбар

Банк бус салбарын гадаад пассив 2012 оны 2 дугаар улирлын байдлаар 7,956.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 32%-иар буюу 2,531.6 сая ам.доллараар нэмэгдсэн.

Салбарын нийт зээлийн 85% буюу 6,730.7 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулалчийн санхүүжилт бөгөөд үүний 89% буюу 6.0 тэрбум ам.доллар нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчидын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг үзвэл улиралд дунджаар 1.0 тэрбум ам.доллар, 0.3 тэрбум ам.доллар тус тус байснаар өрийн үлдэгдэл тогтмол өссөөр байна.

Гадаад өрийн нэр томьёоны тайлбар

Хувийн хэвшлийн салбарын 8,660.0 сая ам.долларын гадаад өрийн үлдэгдлийг эргэн төлөгдөх хугацаагаар нь тооцоход 1 жил хүртэлх хугацаатай зээл нийт зээлийн 18%-ийг, 2-3 жилийн хугацаатай зээл 26%-ийг, 4-5 жилийн хугацаатай зээл 18%-ийг, үлдсэн буюу 38%-ийг 5-аас дээш жилийн хугацаатай зээл бүрдүүлж байна.


Зээлийн эргэн төлөлтийн энэхүү хуваарь нь өнөөдрийн байдлаарх тооцоолол бөгөөд зээлийн нөхцөл өөрчлөгдөх, хөрөнгө оруулагч зээлийн эх үүсвэрийг компанийн дүрмийн санд оруулах, экспорт хийх зэргээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

Гадаад валютын бүтцийн хувьд 90 орчим хувь нь ам.доллараар, үлдсэн 10 хувь нь евро, юань гэх мэт бусад валютаар төлөгдөнө.


Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая \$)

Үзүүлэлт	6/30/2011	6/30/2012	Өөрчлөлт	
			Дун	Дахин
Нийт гадаад өр	8,117.2	11,435.7	3,318.5	1.4
I. Засгийн газар	1,851.7	2,511.2	659.5	1.4
II. Төв банк	273.0	264.5	-8.5	1.0
III. Банк	567.3	703.2	135.9	1.2
Богино хугацаат	85.6	91.7	6.1	1.1
Урт хугацаат	481.7	611.5	129.8	1.3
IV. Бусад сектор	880.7	1,226.1	345.4	1.4
Богино хугацаат	476.3	652.4	176.0	1.4
Урт хугацаат	404.4	573.7	169.4	1.4
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	4,544.5	6,730.7	2,186.2	1.5


Дүрслэл 10. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 11. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Дүрслэл 12. Хувийн хэвшлийн гадаад өрийн хэмжээ, эргэн төлөлт



ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

2012 оны 2-р улирлын гүйцэтгэл

Үзүүлэлт	2-р улирал			Жилийн өөрчлөлт	
	2010	2011	2012	2012/11	2011/10
I. Урсгал Тэнцэл	-61.8	-575.8	-667.6	-91.8	-514.0
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-10.7	-483.9	-587.2	-103.3	-473.2
1. Бараа	55.5	-214.7	-249.1	-34.4	-270.2
1.1 Ерөнхий эд бараа	-18.3	-240.6	-274.7	-34.1	-222.3
Экспорт Ф.О.Б. (Кредит)	730.5	1,217.4	1,352.5	135.1	486.9
Үүнээс: Зэсийн баяжмал	187.6	256.9	355.1	98.2	69.3
Импорт Ф.О.Б. (Дебит)	-748.8	-1,458.0	-1,627.2	-169.2	-709.2
Үүнээс: Нефтийн бүтээгдэхүүн	-154.6	-180.8	-489.3	-308.4	-26.2
Хүнсний бүтээгдэхүүн	-69.3	-70.8	-152.6	-81.8	-1.5
1.2 Мөнгөжөөгүй алт	79.1	32.8	24.7	-8.1	-46.2
Кредит	79.1	32.8	24.7	-8.1	-46.2
Дебит	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.3 Бусад	-5.3	-6.9	0.8	7.8	-1.6
Кредит	0.1	0.4	1.2	0.8	0.3
Дебит	-5.4	-7.3	-0.4	6.9	-1.9
2. Үйлчилгээ	-66.1	-269.2	-338.1	-68.9	-203.1
2.1 Тээвэр	-29.2	-194.8	-251.2	-56.4	-165.6
Кредит	35.6	58.1	68.4	10.3	22.5
Дебит	-64.8	-252.9	-319.6	-66.7	-188.0
2.2 Аялал	0.3	-25.1	-32.2	-7.1	-25.4
Кредит	62.2	56.8	57.1	0.3	-5.4
Дебит	-62.0	-82.0	-89.3	-7.4	-20.0
2.3 Бусад үйлчилгээ	-37.2	-49.3	-54.7	-5.4	-12.1
Кредит	16.0	32.6	49.3	16.8	16.6
Дебит	-53.1	-81.9	-104.0	-22.1	-28.7
В. Орлого	-89.1	-157.6	-167.6	-10.0	-68.4
1. Ажиллагсдын цалин хөлс	-3.0	-25.1	-53.6	-28.5	-22.1
Кредит	3.5	9.2	7.5	-1.7	5.7
Дебит	-6.5	-34.3	-61.1	-26.8	-27.8
2. Хөрөнгө оруулалтын орлого	-86.2	-132.5	-114.0	18.5	-46.3
Кредит	1.7	4.8	17.6	12.8	3.1
Дебит	-87.8	-137.3	-131.6	5.6	-49.4
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	38.0	65.7	87.2	21.5	27.7
Кредит	68.3	118.8	150.8	32.0	50.5
Дебит	-30.3	-53.1	-63.6	-10.5	-22.9
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	25.5	20.3	11.3	-9.0	-5.2
Кредит	54.4	64.3	70.3	6.0	9.9
Дебит	-28.9	-44.0	-59.0	-15.0	-15.1
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	176.5	973.7	390.7	-583.0	797.2
А. Хөрөнгийн данс	32.2	27.6	24.9	-2.6	-4.6
В. Санхүүгийн данс	144.3	946.1	365.8	-580.4	801.8
1. Шууд хөрөнгө оруулалт	426.5	1,349.9	985.9	-364.0	923.4
1.1 Гадагш хийсэн	-3.7	-17.5	-5.8	11.7	-13.8
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	-3.2	-17.6	-5.7	11.9	-14.4
1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.3 Бусад хөрөнгө	-0.4	0.1	-0.1	-0.2	0.6
1.2 Монголд орсон	430.2	1,367.4	991.8	-375.7	937.3
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	289.4	315.6	338.3	22.7	26.2
1.2.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	21.4	79.2	45.2	-34.0	57.8
1.2.3 Бусад хөрөнгө	119.3	972.6	608.3	-364.3	853.3
2. Багцын хөрөнгө оруулалт	-77.2	-6.3	14.3	20.6	70.9
2.1 Актив	-5.4	-17.0	-3.3	13.7	-11.6
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-1.5	-4.3	-3.3	1.0	-2.7
2.1.2 Өрийн бичиг	-3.9	-12.8	0.0	12.8	-8.8
2.2 Пассив	-71.8	10.7	17.5	6.8	82.5
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	1.0	1.6	5.7	4.1	0.7
2.2.2 Өрийн бичиг	-72.8	9.1	11.8	2.8	81.8
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (цэвэр)	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1 Актив	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2 Пассив	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	-204.9	-397.4	-634.4	-237.0	-192.5
4.1 Актив	-268.1	-617.9	-777.9	-160.0	-349.8
4.1.1 Худалдааны зээл	0.6	-91.7	2.1	93.7	-92.3
4.1.2 Зээл	0.1	-16.0	11.7	27.7	-16.0
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	-268.8	-510.3	-791.7	-281.5	-241.5
4.1.4 Бусад актив	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2 Пассив	63.2	220.5	143.5	-77.0	157.3
4.2.1 Худалдааны зээл	15.9	39.0	84.2	45.2	23.1
4.2.2 Зээл	68.7	177.7	51.0	-126.7	109.0
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	-21.4	3.8	8.3	4.4	25.2
4.2.4 Бусад пассив	0.0	0.0	0.0	0.0	0.0
III. Алдаа болон орхигдуулга	47.7	-217.3	389.2	606.5	-265.0
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	162.4	180.6	112.3	-68.3	18.2
IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*	-162.4	-180.6	-112.3	68.3	-18.2

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус

Экспортын жилийн өсөлт /ФОВ/ хувиар		54.5	10.2
Импортын жилийн өсөлт /ФОВ/ хувиар		94.3	11.1
Гадаад валютын цэвэр албан нөөц, өссөн байдлаар /сая ам.долл	1,229.8	2,339.5	2,718.1
Төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш	1,383.4	1,237.6	1,319.7

ХАВСРАЛТ 3. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (мянган ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	3/31/2011	6/30/2011	9/30/2011	12/31/2011	3/31/2012	6/30/2012
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)	-1,678,373.3	-2,509,637.6	-4,296,999.8	-6,422,357.7	-7,692,293.0	-9,040,950.1	-10,082,720.7
I. Гадаад актив	6,549,066.2	6,845,917.2	6,891,349.4	6,150,291.4	5,742,568.3	6,049,327.6	5,820,908.3
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	2,901,429.5	3,281,159.9	3,029,161.6	2,197,678.0	1,859,166.2	1,699,345.0	1,062,502.4
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	2,899,484.5	3,279,214.9	3,027,019.0	2,195,535.4	1,857,023.6	1,697,202.4	1,060,359.8
1.1.1 Салбар компаниас авах	2,899,484.5	3,279,214.9	3,027,019.0	2,195,535.4	1,857,023.6	1,697,202.4	1,060,359.8
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2 Бусад хөрөнгө	1,945.0	1,945.0	2,142.6	2,142.6	2,142.6	2,142.6	2,142.6
1.2.1 Салбар компаниас авах	1,945.0	1,945.0	2,142.6	2,142.6	2,142.6	2,142.6	2,142.6
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Багцын хөрөнгө оруулалт	45,438.8	56,097.5	73,142.1	91,736.4	24,505.5	27,690.8	24,393.3
2.1 Хөрөнгийн хувьцаа	359.3	4,438.2	8,709.9	12,175.2	20,367.8	23,536.1	20,221.5
2.1.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.3 Банкууд	3.2	3.4	3.5	3.3	3.2	3.3	3.1
2.1.4 Бусад салбар	356.1	4,434.8	8,706.4	12,171.9	20,364.6	23,532.8	20,218.5
2.2 Өрийн бичиг	45,079.5	51,659.3	64,432.1	79,561.2	4,137.8	4,154.8	4,171.7
2.2.1 Бонд, үнэт цаас	44,972.6	51,484.1	64,615.0	75,612.8	211.1	223.3	199.2
2.2.1.1 Төвбанк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.3 Банкууд	164.5	175.6	178.3	157.0	158.1	170.3	152.2
2.2.1.4 Бусад салбар	44,808.1	51,308.5	64,436.7	75,455.7	53.0	53.0	47.0
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	106.8	175.2	-182.9	3,948.4	3,926.6	3,931.5	3,972.6
2.2.2.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.3 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.4 Бусад салбар	106.8	175.2	-182.9	3,948.4	3,926.6	3,931.5	3,972.6
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	46.4	5,846.2	260.7	273.2	1,488.0	434.8	462.5
3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.3 Банкууд	46.4	5,846.2	260.7	273.2	1,488.0	434.8	462.5
3.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	1,314,200.3	1,159,308.4	1,247,162.2	1,254,589.9	1,406,817.1	1,417,246.9	1,825,386.3
4.1 Худалдааны зээллэг	106,576.1	181,272.8	267,279.4	275,934.6	349,089.0	401,678.3	496,270.1
4.1.1 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2 Бусад салбар	106,576.1	181,272.8	267,279.4	275,934.6	349,089.0	401,678.3	496,270.1
Урт хугацааны	15,888.4	20,266.9	30,777.4	27,662.0	23,309.6	20,906.1	40,210.0
Богино хугацааны	90,687.7	161,005.8	236,502.0	248,272.6	325,779.4	380,772.2	456,060.1
4.2 Зээл	18,447.4	14,228.2	8,870.5	9,025.2	8,845.7	21,602.7	21,666.1
4.2.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.3 Банкууд	18,447.4	14,228.2	8,870.5	9,025.2	8,845.7	21,602.7	21,666.1
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	18,447.4	14,228.2	8,870.5	9,025.2	8,845.7	21,602.7	21,666.1
4.2.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	1,189,176.8	963,807.4	971,012.3	969,630.2	1,048,882.4	993,965.9	1,307,450.1
4.3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.3 Банкууд	503,437.6	457,944.7	489,379.0	451,508.9	509,278.1	457,280.0	502,934.8
4.3.4 Бусад салбар	685,739.3	505,862.7	481,633.2	518,121.3	539,604.3	536,685.9	804,515.3
4.4 Бусад актив	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.3 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5. Нөөц актив	2,287,951.1	2,343,505.3	2,541,622.9	2,606,013.9	2,450,591.4	2,904,610.1	2,908,163.9

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2010	3/31/2011	6/30/2011	9/30/2011	12/31/2011	3/31/2012	6/30/2012
II. Гадаад пассив	8,227,439.5	9,355,554.9	11,188,349.2	12,572,649.1	13,434,861.4	15,090,277.7	15,903,629.0
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	4,949,547.4	5,990,938.3	7,489,130.5	8,855,496.3	9,461,651.7	10,408,476.1	11,082,520.4
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	2,234,270.2	2,547,413.9	2,942,083.9	3,419,118.3	3,711,299.8	3,969,748.4	4,351,800.2
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	2,234,270.2	2,547,413.9	2,942,083.9	3,419,118.3	3,711,299.8	3,969,748.4	4,351,800.2
1.2 Бусад хөрөнгө	2,715,277.2	3,443,524.3	4,547,046.6	5,436,378.0	5,750,351.9	6,438,727.6	6,730,720.2
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	2,715,277.2	3,443,524.3	4,547,046.6	5,436,378.0	5,750,351.9	6,438,727.6	6,730,720.2
2. Багцын хөрөнгө оруулалт	275,242.3	321,380.0	302,457.8	324,675.4	337,305.3	906,312.3	913,914.8
2.1 Хөрөнгийн хувьцаа	65,158.7	121,610.3	94,596.3	104,098.5	94,553.7	89,635.5	85,659.9
2.1.1 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2 Бусад салбар	65,158.7	121,610.3	94,596.3	104,098.5	94,553.7	89,635.5	85,659.9
2.2 Өрийн бичиг	210,083.6	199,769.7	207,861.5	220,576.9	242,751.6	816,676.8	828,254.9
2.2.1 Бонд, үнэт цаас	210,083.6	199,769.7	207,861.5	220,576.9	242,751.6	816,676.8	828,254.9
2.2.1.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.1.2 Засгийн газар	19,005.6	19,931.2	24,835.5	28,078.8	46,106.7	619,654.4	619,422.1
2.2.1.3 Банкууд	191,078.0	179,838.4	182,519.4	191,776.9	195,696.0	195,912.8	207,636.5
2.2.1.4 Бусад салбар	0.0	0.0	506.6	721.2	948.9	1,109.6	1,196.2
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.3 Банкууд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.2.2.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	46.7	5,181.6	261.4	270.3	1,489.2	435.0	462.6
3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.3 Банкууд	46.7	5,181.6	261.4	270.3	1,489.2	435.0	462.6
3.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	3,002,603.1	3,038,055.0	3,396,499.5	3,392,207.1	3,634,415.1	3,775,054.3	3,906,731.2
4.1 Худалдааны зээллэг	187,257.5	178,113.2	203,184.4	110,938.2	90,165.3	206,615.0	277,561.5
4.1.1 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2 Бусад салбар	187,257.5	178,113.2	203,184.4	110,938.2	90,165.3	206,615.0	277,561.5
Урт хугацааны	24,295.0	28,040.9	30,255.4	3,185.3	14,929.2	28,026.1	43,650.4
Богино хугацааны	162,962.5	150,072.3	172,929.0	107,752.9	75,236.1	178,588.9	233,911.1
4.2 Зээл	2,698,726.5	2,739,149.9	3,022,859.6	3,093,703.1	3,290,616.4	3,358,734.6	3,394,909.9
4.2.1 Төв банк	273,602.4	279,073.2	280,107.9	275,384.5	267,689.0	268,870.3	264,461.2
ОУВС-гийн зээл	272,732.5	278,654.4	279,693.3	274,977.9	267,288.5	268,593.8	264,190.9
Бусад урт хугацааны	869.9	418.8	414.7	406.7	400.5	276.5	270.3
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2 Засгийн газар	1,768,567.8	1,778,343.0	1,826,852.2	1,807,922.5	1,904,761.0	1,913,729.3	1,891,810.1
Урт хугацааны	1,768,567.8	1,778,343.0	1,826,852.2	1,807,922.5	1,904,761.0	1,913,729.3	1,891,810.1
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.3 Банкууд	198,240.8	194,725.0	228,130.5	249,036.1	260,567.2	253,412.1	291,298.5
Урт хугацааны	121,388.3	125,867.3	159,295.7	169,115.8	178,855.2	176,772.5	199,576.2
Богино хугацааны	76,852.5	68,857.7	68,834.8	79,920.3	81,712.0	76,639.6	91,722.3
4.2.4 Бусад салбар	458,315.5	487,008.7	687,769.0	761,360.0	857,599.1	922,722.9	947,340.2
Урт хугацааны	332,631.3	297,150.1	376,688.5	398,563.1	431,280.5	484,852.1	528,871.6
Богино хугацааны	125,684.3	189,858.6	311,100.5	362,796.8	426,318.7	437,870.8	418,468.6
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	34,619.1	38,791.9	46,455.6	63,565.7	129,633.5	85,704.6	110,259.9
4.3.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.3.3 Банкууд	34,619.1	38,791.9	46,455.6	63,565.7	129,633.5	85,704.6	110,259.9
4.3.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4 Бусад пассив	82,000.0	82,000.0	124,000.0	124,000.0	124,000.0	124,000.0	124,000.0
4.4.1 Төв банк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.2 Засгийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.3 Банкууд	82,000.0	82,000.0	124,000.0	124,000.0	124,000.0	124,000.0	124,000.0
Урт хугацааны	82,000.0	82,000.0	124,000.0	124,000.0	124,000.0	124,000.0	124,000.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.4.4 Бусад салбар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урт хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Богино хугацааны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (мянган ам.доллар)

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012Q1	2012. Q2
Засгийн газар	1,602,179.3	1,818,075.7	1,766,993.4	1,927,195.0	2,533,383.7	2,511,232.2
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Мөнгөний захын хэрэгслүүд	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0
Худалдааны зээл	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0
Урт хугацаат	1,602,179.3	1,818,075.7	1,766,993.4	1,927,195.0	2,533,383.7	2,511,232.2
Бонд, өрийн бичиг	0	66,247.7	18,994.9	22,434.0	619,654.4	619,422
Зээл	1,602,179.3	1,751,828.0	1,747,998.5	1,904,761.0	1,913,729.3	1,891,810
Худалдааны зээл	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0
Төвбанк	752.3	245,607.6	264,493.6	267,689.0	268,870.3	264,461.2
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Мөнгөний захын хэрэгслүүд	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0
Харилцах, хадгаламж	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0
Урт хугацаат	752.3	245,607.6	264,493.6	267,689.0	268,870.3	264,461.2
Бонд, өрийн бичиг	0	0	0	0	0	0
Зээл	752.3	245,607.6	264,493.6	267,689.0	268,870.3	264,461
Харилцах, хадгаламж	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0
Банк	365,849.5	341,077.0	483,612.2	684,851.0	659,029.5	703,194.9
Богино хугацаат	66,947.9	112,704.8	76,852.5	98,516.3	76,639.6	91,722.3
Мөнгөний захын хэрэгслүүд	0	0	0	0	0	0.0
Зээл	66,947.9	112,704.8	76,852.5	98,516.3	76,639.6	91,722.3
Харилцах, хадгаламж	0	0	0	0	0	0
Бусад өглөг	0	0	0	0	0	0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0
Урт хугацаат	298,901.6	228,372.2	406,759.7	586,334.7	582,389.9	611,473
Бонд, өрийн бичиг	87,000.0	59,000.0	198,000.0	200,500.0	195,912.8	207,636.5
Зээл	116,105.1	115,293.0	117,156.3	235,356.0	176,772.5	199,576.2
Харилцах хадгаламж	75,796.5	22,079.2	34,603.4	129,633.5	85,704.6	110,259.9
Бусад өглөг	20,000.0	32,000.0	57,000.0	20,845.2	124,000.0	94,000.0
Бусад сектор	124,474.9	361,725.6	588,436.6	994,046.2	1,130,447.6	1,226,097.8
Богино хугацаат	2,675.0	135,478.6	235,965.6	548,775.2	617,569.3	652,379.6
Мөнгөний захын хэрэгслүүд	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Зээл	2,675.0	12,175.0	87,404.0	378,824.5	437,870.8	418,468.6
Харилцах хадгаламж	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Худалдааны зээл	n/a	123,303.6	148,561.7	169,950.7	178,588.9	233,911.1
Бусад өглөг	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Хугацаа хэтэрсэн төлбөр	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Бусад	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Урт хугацаат	121,799.9	226,247.0	352,471.0	445,271.0	512,878.3	573,718.2
Бонд, өрийн бичиг	0.0	0.0	0.0	0.0	1,109.6	1,196.2
Зээл	121,799.9	194,731.9	328,421.0	430,452.0	484,852.1	528,871.6
Харилцах хадгаламж	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Худалдааны зээл	n/a	31,515.1	24,050.0	14,819.0	28,026.1	43,650.4
Бусад өглөг	n/a	n/a	n/a	n/a	n/a	n/a
Шууд хөрөнгө оруулалт:	90,259.4	219,280.5	893,399.0	5,747,805.7	6,438,727.6	6,730,720.2
Компани хоорондын зээллэг	90,259.4	219,280.5	893,399.0	5,747,805.7	6,438,727.6	6,730,720.2
Хамааралтай ААНБ-ийн өглөг	0	0	0	0	0	0.0
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	0	0	0.0
Бусад	0	0	0	0	0	0.0
Шууд хөрөнгө оруулагчийн өглөг	90,259.4	219,280.5	893,399.0	5,747,805.7	6,438,727.6	6,730,720.2
Хугацаа хэтэрсэн төлбөр	0	0	0	1	0	0.0
Бусад	90,259.4	219,280.5	893,399.0	5,747,804.7	6,438,727.6	6,730,720.2
НИЙТ ГАДААД ӨР	2,183,515.3	2,985,766.4	3,996,934.8	9,621,586.9	11,030,458.7	11,435,706.3

* Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг хангах, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг багасгах зорилгоор ОУВС-гаас "Стэнд-бай" хөтөлбөрийн хүрээнд авсан 122.6 сая ЗТЭ-ийн хөрөнгийн эх үүсвэр орсон болно.